

# “Глобал Монголиа Холдингс ХК”

2023 оны жилийн үйл ажиллагааны тайлагнал

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа /Жишээ нь:  
2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/

2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

Үнэт цаас гаргагчийн нэр,  
улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар

Нэр: “Глобал Монголиа Холдингс” ХК  
УБ гэрчилгээний дугаар: 9010001113  
Үнэт цаасны код:  
**MN00HML01255**  
Утасны дугаар: 7000 2062

Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр

Монголын Хөрөнгийн Бирж ХК

Бизнесийн үйл ажиллагааны салбар

Гоо сайхны бүтээгдэхүүний худалдаа;  
Гоо сайхны бүтээгдэхүүний худалдаа;  
Гоо сайхны бүтээгдэхүүний үйлдвэрлэл;  
Худалдааны зуучлал;  
Онлайн дэлгүүр;  
Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн худалдаа;  
Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ;  
Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр зөвлөгөө өгөх;  
Хоёрдогч түүхий эд боловсруулах;  
Сүлжмэл, нэхмэл эдлэлийн үйлдвэрлэл;  
Хивс, хивсэнцэр үйлдвэрлэл;  
Бэлэн хувцас үйлдвэрлэл;  
Гэрээгээр өрөмдлөгө хийх;  
Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх;  
Фермерийн аж ахуй;  
Програм хангамжийн үйл ажиллагаа;  
Компьютерын засвар үйлчилгээ, зөвлөгөө өгөх;  
Мэдээлэл технологийн үйл ажиллагаа;  
Вэб сайтын үйлчилгээ;

	<p>Санхүүгийн тайлан баланс бэлтгэн гаргах түүнтэй холбоотой зөвлөгөө өгөх;          Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа;          Байгалийн ухааны эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны ажил;          Зах зээлийн болон социологийн судалгаа хийх;          Сүлжмэл, нэхмэл эдлэл, гутлын худалдаа;          Бэлэн хувцас худалдаа;          Хүнд машин механизмын тоног төхөөрөмжийн түрээс;          Аялал жуулчлал;          Бизнесийн зөвлөгөө өгөх; болон          хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа.</p>			
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Сүлд Аудит ХХК			
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	107,306			
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Ерөнхий нягтлан бодогч М.Дариймаа Хянасан: Захирал Бэк Квангюэл			
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/			
		Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	<i><b>Хоронго</b></i>		
		Эргэлтийн хөрөнгө:	14,568,100.00	14,568,099.22
		Эргэлтийн бус хөрөнгө:	-	-
		Нийт хөрөнгө:	14,568,100.00	14,568,099.22
		<i><b>Өр төлбөр ба эздийн өмч</b></i>		
		Богино хугацаат өр төлбөр	8,336,200.00	15,757,242.00
		Эздийн өмч:	10,730,600.00	10,730,600.00
	<b>Нийт өр ба эздийн өмч:</b>	<b>14,568,100.00</b>	<b>14,568,099.22</b>	
	Орлогын тайлан	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл

		Борлуулалтын орлого:	-	-
		Нийт орлого:	-	-
		Ерөнхий ба удирдлагын зардал:	-	7,421,050.00
		Татвар төлөхийн өмнөх ашиг, (алдагдал):	-	(7,421,050.00)
		Тайлант үеийн цэвэр ашиг, (алдагдал):	-	(7,421,050.00)
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
		Өмч:	10,730,600.00	10,730,600.00
		Хуримтлагдсан ашиг	(-4,498,692.78)	(-11,919,742.78)
		Нийт эздийн өмчийн дүн	(-1,189,142.78)	
		2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар:		
	Мөнгөн гүйлгээний тайлан	Үндсэн ҮАМГ: -15,757,242.00		
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт			
	2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд “Сүлд Аудит” ХХК хөндлөнгийн хараат бус аудитын дүгнэлт гаргасан. Аудитын дүгнэлтийг хавсаргав.			
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/			
	Аудитын тодорхойлох захидлыг хавсаргав.			
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл			
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	2023 онд Компани нь идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй тул эдгээр үзүүлэлтүүдийг тодорхойлоогүй болно.		
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт			
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд	2023 оныг хүртэл компанийн үйл ажиллагаа бүхэлдээ зогсонги байдалтай байсан билээ. Энэхүү хүнд байдлаас гарахын тулд стратегийн хөрөнгө оруулагчаас хөрөнгө оруулалт татан нэмж хувьцаа гаргахын тулд зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх шаардлага гарсан. Тиймээс Компани нь 2023 оны 12 дугаар сарын 10-нд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулж компанийн зарласан хувьцааны тоог нэмэгдүүлж, нэмж хувьцаа гарган,		

	<p>гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</p>	<p>стратегийн хөрөнгө оруулагчид эзэмшүүлэх тухай шийдвэрийг гаргасан. СЗХ болон МХБ-ээс холбогдох зөвшөөрлийг аван улмаар үе шаттайгаар хөрөнгө оруулалтаа татах, зарласан хувьцааны тоог хүрэлцээтэйгээр нэмэгдүүлэх мөн үйл ажиллагааны чиглэлдээ хэд хэдэн чиглэлийг нэмж, компанийн үйл ажиллагааны хүрээг өргөжүүлжэхээр ажиллаж байна. Цаашлаад стратегийн хөрөнгө оруулагчаас хөрөнгө оруулалт татан, компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, гаргасан болон зарласан хувьцааны тоо ширхэг, дүрэмд холбогдох өөрчлөлтийг 2024 онд оруулах болно.</p>
2.4.	<p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</p>	<p>Санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.</p>
2.5.	<p>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</p>	<p>Тайлант хугацаанд зээл аваагүй мөн зээлийн эргэн төлөлт хийгдээгүй.</p>
3.	<p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p>	
	<p>Тайлант хугацаанд Компани нь сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийг хийгээгүй болно.</p>	
4.	<p>Цалин урамшууллын мэдээлэл</p>	
	<p>Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн № 02/23 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороодыг томилж, бүрэлдэхүүнийг шинээр томилсон байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн № 02/23 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар “Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам”-ыг баталсан. ТУЗ-ийн цалин, урамшууллын хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны санал болгосноор ТУЗ баталдаг. Цаашид буюу 2024 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаас эхлэн ТУЗ-ийн гишүүдийн цалин</p>	

	<p>урамшууллыг хувьцаа эзэмшигчдээр хэлэлцүүлэн батлуулахаар төлөвлөж байна. Компанийн хувьд ТУЗ-ийн цалин, урамшууллыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн батлуулах бүрэн боломжтой юм.</p>
5.	<p>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</p>
	<p>Компанийн засаглалын кодексын хүрээнд холбогдох дүрэм, журам, заавар, бодлогыг 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар батлан, үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байна. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээний тайланг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, мэдээлсэн ба улмаар хянан баталгаажуулан цаашид үе шаттайгаар сайжруулахаар төлөвлөж байна.</p> <p>Компани нь нийтэд <a href="https://gmholdings.imweb.me/about">https://gmholdings.imweb.me/about</a> цахим хуудсаараа дамжуулан мэдээллийг нээлттэй мэдээллэдэг ба кодекст заасан засаглалын дараах баримт бичиг, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж, цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;</li> <li>• Залгамж халааны бодлогын баримт бичиг;</li> <li>• Дотоод аудитын заавар;</li> <li>• Цалин, хөлс урамшууллын журам;</li> <li>• Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам;</li> <li>• Эрсдэлийн удирдлагын журам;</li> <li>• Комплайнсын хяналтын заавар;</li> <li>• Хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудтай харилцах хөтөлбөр;</li> <li>• Шүгэл үлээх бодлого;</li> <li>• Сургалтын төлөвлөгөө;</li> <li>• Ёс зүйн дүрэм;</li> <li>• Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам;</li> <li>• Аудитын хорооны үйл ажиллагааны журам;</li> <li>• Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам.</li> </ul> <p>✓ “Глобал Монголиа Холдингс” ХК нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн удирдах зөвлөлтэй.</p> <p>✓ Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн № 01/23 тоот тогтоолоор Ким Ки Хюун, Бэк Квангюэл, Хан Бэк, Ким Ду Хван, Э.Гандиймаа нарыг ТУЗ-ийн ердийн гишүүнээр, Ц.Тогоо, М.Лхамсүрэн, Б.Ананд нарыг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус томилсон.</p> <p>✓ Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн № 05/23 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулсан зохицуулсан байхаас гадна компани нь ямар асуудлаар, ямар журмаар хөндлөнгийн мэргэжлийн этгээдийн зөвлөгөөг компанийн зардлаар авч болох талаар тодорхой тусгасан.</p>

	<ul style="list-style-type: none"> <li>✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн № 02/23 тоот тогтоолоор “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам”-ыг баталсан.</li> <li>✓ “Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам”-аар ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид тавигдах шаардлагыг тодорхойлж, сонгон шалгаруулалтын процесс, ТУЗ-ийн гишүүний ажлыг үнэлэх журам, цалин урамшууллыг тодорхойлох журам, хараат бус байдлыг хангах арга, хяналтын зохицуулалт зэргийг тодорхойлсон.</li> <li>✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн № 05/23 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Залгамж халааны бодлого”-ын баримт бичгээр ТУЗ-ийн залгамж халааны төлөвлөлт, Гүйцэтгэх удирдлагын залгамж халааны төлөвлөлт, гэнэтийн нөхцөлд авах арга хэмжээ, томилгоо, ил тод байдал, хяналт, сайжруулалт зэрэг харилцааг зохицуулсан.</li> </ul>
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл
	Компаний нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид гадаад улсын иргэд тул Гадаадын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахтай холбоотой хууль эрх зүйн орчны тогтворгүй байдал, Монгол улсын засгийн газрын бодлого зэрэг нь компанийн тогтвортой үйл ажиллагаанд тодорхой хэмжээнд нөлөөлдөг. Мөн Орос-Украины хямралаас үүдэлтэй өндөр инфляцийн түвшин (16.5% ↑) болон валютын ханшийн тогтворгүй байдлын улмаас дотоодын эдийн засагт хүндрэл учруулж байна.
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/
	Park Chan Soo – 29,200 ш /27.21%/ Chang Kyoung Suk – 35,400 ш /32.99%/ С.Баасанхүү – 8,008 ш /7.5%/
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл
	Үнэт цаас гаргагч нь 2023 онд нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.
9.	Ногдол ашгийн мэдээлэл
	2023 оны санхүүгийн жилд компанийн үйл ажиллагаа идэвхгүй байсан тул ТУЗ-ийн 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн хурлаас гаргасан тогтоолын дагуу ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл

Тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажил байхгүй.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:  
2024/03/29

Овог, нэр: Бэк Квангюэл

Албан тушаал: "Глобал Монголиа Холдингс" ХК-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг: .....



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Хажидмаа

Албан тушаал: Хуульчийн туслах

Гарын үсэг: ..... *Г.Хажидмаа* /